

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА, БРИГАДЫН
ГЕНЕРАЛ *Г. АРИУНБУЯН*

2019 оны 05 сарын 27 өдөр

ОРОН СУУЦНЫ ЗОРИУЛАЛТТАЙ 12 БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ДАВХАР БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ГАЛ УНТРААХ АВТОМАТ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ГАЛЫН
ДОХИОЛЛЫН ХЭРЭГСЭЛ, АВРАЛТЫН ЗАМ ГАРЦ, УСАН ХАНГАМЖИД
ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Хяналт шалгалтын зорилго, чиглэл

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдалтай холбоотой стандарт норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг орон сууцны зориулалттай 12 болон түүнээс дээш давхар барилга байгууламжид зохион байгуулж, болзошгүй эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм, нормативын баримт бичиг нь уг шалгалтыг явуулах эрх зүйн үндэс болно.

2.2. Хяналт шалгалтад оролцох бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3. Төв, орон нутагт байршилтай орон сууцны зориулалттай 12 болон түүнээс дээш давхар барилга байгууламжид хяналт шалгалтыг зохион байгуулна.

2.4. Гал түймрийн улсын хяналтын байцаагчид нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэн, илэрсэн зөрчлийг арилгуулах, цаг хугацаа, хөрөнгө шаардсан зөрчилд хугацаатай байцаагчийн Заавал биелүүлэх албан шаардлага, Дүгнэлт, Мэдэгдэл тухайн хотхон, байрны Сууц өмчлөгчдийн холбооны холбогдох албан тушаалтанд хүргүүлж, зөрчил арилаагүй тохиолдолд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулна.

2.5. Хяналт шалгалтыг хотхон, байр, орц тус бүрээр хавсралтад заасан мэдээллийн дагуу гүйцэтгэн удирдамжийн 3.4-т заасан хаягаар цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.6. Хяналт шалгалт хийсэн тухай мэдээллийг улсын хяналтын байцаагчийн өдөр тутмын ажлын мэдээний цахим бүртгэлийн программын мэдээллийн санд нэг бүрчлэн оруулсан байна.

Гурав. Хяналт шалгалт явуулах хугацаа, зардал

3.1.Хяналт шалгалтын ажлын хэсгийг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга томилон удирдлагаар хангаж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан зохион байгуулна.

3.2.Хяналт шалгалт явуулахад шаардлагатай зардлыг тухайн орон нутгийн Онцгой байдлын байгууллага хариуцна.

3.3.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 03-ны өдрийн хооронд зохион байгуулна.

3.4.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүн, хүснэгтэн мэдээг 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн Hyanaltiinheltes.obeg@yahoo.com цахим хаягаар зөрчлийг фото зургаар баримтжуулан илтгэх хуудсын хамт ирүүлнэ.

Дөрөв. Хяналт шалгалтын үр дүн, авах арга хэмжээ

4.1.Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын вэб хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэнэ.

4.2.Онцгой байдлын ерөнхий газраас хяналт шалгалтын дүн, санал дүгнэлтийн талаарх танилцуулгыг шалгалтад хамрагдсан байгууллагуудын харьяалах байгууллагад хүргүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шат дараатай авч хэрэгжүүлнэ.

4.3.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулж, Сууц өмчлөгчдийн холбооны дарга нарт гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчийн танилцуулга, мэдэгдэл, заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулна.